



**ХАСБАНК**

# **ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 12-р сарын 31-ны байдлаар





## Агуулга

1. Онцлох үйл явдал	03-04
2. Санхүүгийн үзүүлэлтүүд	05-10
3. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	11-12
4. Компанийн засаглал	13



# Онцлох үйл явдал

2025 оны IV улирал

## Global Finance

Global Finance сэтгүүлээс ХасБанкийг МУ-ын шилдэг банкаар шалгаруулж, шагналыг 10-р сарын 18-нд Вашингтон хотод гардууллаа.

## Онцлох ТоС Банк

ХасБанк 2025 оны “Онцлох ТоС Банк”-аар дахин шалгарлаа. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага болон Уур амьсгалын эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, өөрийн зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой хүлэмжийн хийн (CO<sub>2</sub>) ялгарлыг тооцоолж, олон улсын PCAF (Partnership for Carbon Accounting Financials) санаачилгад тайлангаа амжилттай нийтлэн, “Тайлагнасан” гэсэн статусыг авсан нь 2025 оны онцлох үйл явдал байлаа.



## Moody's B1 Rating

Олон улсын үнэлгээний Moody's Ratings агентлаг ХасБанкны урт хугацааны зээлжих зэрэглэлийг B2-оос B1 (тогтвортой) болгон нэг шат ахиуллаа. МУ-ын Засгийн Газрын зээлжих зэрэглэл ахисан болон ХасБанкны санхүүгийн үзүүлэлт тогтвортой сайжирсан зэрэг нь ХасБанкны урт хугацааны зээлжих зэрэглэл (Deposit rating, Issuer rating)-ийг ахиулах нөхцөл болсныг Moody's дурдаад, ийнхүү ахиулсан Монгол Улсын хоёр банкны нэг нь ХасБанк болсон юм.



# Онцлох үйл явдал

2025 оны IV улирал



**Teen card**  
Шинэ картууд гарлаа

ХасБанк хүүхэд, өсвөр үеийнхний санхүүгийн боловсрол, өдөр тутмын санхүүгийн хэрэглээг дэмжих зорилготой ХасTeen картыхаа шинэчлэгдсэн, өвөрмөц загваруудыг танилцууллаа. Карт захиалснаар ХасTeen апп-тай холбогдож, картын үлдэгдлээ шалгах, шилжүүлэг хийх зэрэг өдөр тутмын санхүүгийн хэрэглээгээ хүүхэд өөрөө бие даан удирдах боломжтой.



**150 сая ам.долларын синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа**

ХасБанк Нидерландын Хөгжлийн Банкнаас 150 сая ам.долларын санхүүжилт авах синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа. Уг санхүүжилт нь бүхэлдээ бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихэд зориулагдах бөгөөд залуу болон эмэгтэй бизнес эрхлэгчид, мөн хөдөө аж ахуйн салбарын бизнесүүдэд түлхүү чиглэх бол үлдсэн хэсэг нь байгаль орчинд ээлтэй, ногоон бизнес, мөн ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулагдах юм.



# Онцлох үйл явдал

2025 оны IV улирал

## Дижитал шилжилт:



### **Ebarimt** хялбар бүртгэл

ХасБанкны картаар хийсэн худалдан авалтын төлбөрийн баримт Ebarimt-ын системд автоматаар бүргэгддэг боллоо.



### **IBAN** лавлах үйлчилгээ

IBAN лавлах үйлчилгээ шинэчлэгдсэнээр Дижитал банк, InstaXPay, ХасTeen+ app-уудаар гүйлгээ хийхэд илүү хялбар боллоо.



### **UnionPay** картаа

Alipay болон Wechat апп-уудад холбон, худалдан авалт, төлбөр тооцоогоо шимтгэлгүй хийх боломжтой боллоо.



# Санхүүгийн үр дүн



2025 оны IV улирал

Цэвэр ашиг	ROE	ХАС (Хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮172.6 тэрбум	21.8%	₮963.9	₮164.1	20.1%	37.6%

## Ашигт ажиллагаа

- 2025 оны IV улиралд ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 47.6 тэрбум төгрөгт хүрч, 2025 оныг нийт 172.6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай өндөрлөлөө. 2025 онд Банкны зээлийн багцын өсөлтийг даган хүүгийн орлого өссөн боловч төв банкны своп хэлцлийн хүүгийн зардал нэмэгдсэн, мөн заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна. Мөн түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан банкны чанаргүй зээлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад өссөн нь сангийн зардлыг нэмэгдүүлсэн байна.
- 2025 оны IV улирлын байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 21.8 хувь, нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 164.1 төгрөг байна.

## Баланс

- 2025 оны IV улиралд нийт зээлийн багц 4,183 тэрбум төгрөгт хүрч, өмнөх улирлаас 1.0 хувиар, оны эхнээс 13.1 хувиар өслөө.
- Иргэдийн банкны зээлийн багц оны эхнээс 4.8 хувиар өсөж 2,710 тэрбум төгрөгт хүрэхэд хэрэглээний болон бичил, ЖДБ зээлийн өсөлт нөлөөлжээ.
- ХасЛизингийн санхүүгийн түрээс болон зээлийн багц 659 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 41.1 хувь, өмнөх улирлаас 3.6 хувиар өслөө. IV улиралд шинэ автомашины зээлийн үлдэгдэл 7.4 хувиар, оны эхнээс 43.9 хувиар өссөн бол дугаартай автомашины зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 2.7 хувиар буурч, оны эхнээс 50.6 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд ХасMortgage үйлчилгээг өргөжүүлсний үр дүнд ХасЛизингийн багц дахь орон сууцны зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 49.1 хувиар, оны эхнээс 81.2 хувиар өссөн байна.
- Байгууллагын банкны зээлийн багц өмнөх улирлаас 13.9 хувиар, оны эхнээс 26.6 хувиар өсөж 815 тэрбумд төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээлийн харьцаа 2.5 хувь байгаа нь банкны салбарын тэргүүлэх үзүүлэлт юм.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ өмнөх улирлаас 5.7 хувиар, оны эхнээс 9.4 хувиар өсөж 3,749 тэрбум төгрөгт хүрлээ. 2025 оны IV улиралд хуваарийн дагуу нийт 113 сая ам.доллар эх үүсвэрийг эргүүлэн төлсөн ба үүний үр дүнд гадаад эх үүсвэрийн үлдэгдэл өмнөх улирлаас 12.1 хувиар буурч 548 сая ам.долларт хүрлээ.

## Харьцаа үзүүлэлт

- 2025 оны IV улирлын байдлаар Монголбанкнаас тогтоосон харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохистой хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 20.1 хувь буюу доод хэмжээг 7.6 нэгж хувиар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 37.6 хувьтай байгаа нь зохистой харьцааг хангаж байна.




# Санхүүгийн үзүүлэлтийн тренд

2025 оны IV улирал

## Цэвэр ашиг

Тэрбум төгрөг



## Нийт актив

Тэрбум төгрөг




## Зээлийн багц

Тэрбум төгрөг



## Өөрийн хөрөнгийн өгөөж

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



## 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



## Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа





# Зээлийн үйл ажиллагаа

2025 оны IV улирал

Нийт зээлийн тоо	Иргэдийн банк зээлийн тоо	Байгууллагын банк зээлийн тоо	ХасЛизинг с.түрээсийн тоо	Онлайн зээлийн тоо
216.1 <span>мянга</span> ▼ -2.5% QoQ ▲ +14.1% YTD	210.7 <span>мянга</span>	0.2 <span>мянга</span>	5.2 <span>мянга</span>	144.6 <span>мянга</span> ▼ -3.0% QoQ ▲ +16.7% YTD


## Зээлийн багц

Тэрбум төгрөг



## Зээлийн багц бизнесийн сегментээр

Тэрбум төгрөг ■ 25-III ■ 25-IV



- Иргэдийн банкны зээлийн багц өмнөх улирлаас 2.9 хувиар буурч 2,710 тэрбум төгрөгт хүрлээ. IV улиралд 99.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг МИК-д шилжүүлсэн, мөн цахим зээлийн шаардлагыг чангалсан нь зээлийн багц буурахад нөлөөлсөн байна.
- ХасЛизингийн санхүүгийн түрээсийн багцын өсөлтөд автомашины санхүүгийн түрээс болон орон сууцны зээлийн өсөлт голчлон нөлөөлсөн байна.



# Дотоод эх үүсвэр

2025 оны IV улирал


Нийт дансны тоо
<b>1.5сая</b> ▲ 1.2% QoQ ▲ 9.2% YTD

Харилцах дансны тоо	Хадгаламжийн дансны тоо
<b>955.3</b> мянга	<b>559.7</b> мянга

Нийт харилцагчдын тоо
<b>1.2сая</b> ▲ 1.0% QoQ ▲ 8.0% YTD


## Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөг



## Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- 2025 оны IV улиралд ХасБанкны харилцах дансны үлдэгдэл 946 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 19.3 хувиар өслөө.
- Нийт хадгаламж өмнөх улирлаас 1.8 хувиар өсөж 2,803 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд хадгаламжийн өсөлтөд Ирээдүйн саятан хүүхдийн хадгаламж, хугацаатай болон хугацаагүй хадгаламж тус тус 1.6-1.9 хувиар өсөн жигд нөлөөлсөн байна.




# Гадаад эх үүсвэр

2025 оны IV улирал

2025 оны IV улиралд нийт 29.3 сая ам.долларын гадаад эх үүсвэрийг BlueOrchard (10 сая), Incofin (15 сая), Symibotics (4.3 сая) зэрэг олон улсын байгууллагуудаас татан төвлөрүүлсэн бол хуваарийн дагуу нийт 113 сая ам.долларын эх үүсвэрийг IV улиралд эргүүлэн төллөө. Үр дүнд нийт гадаад эх үүсвэрийн дүн өнгөрсөн улирлаас 12.1 хувиар буурч 548 сая ам.долларт хүрлээ.

## Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



## IV улиралд авсан гадаад эх үүсвэрүүд



**\$150,000,000**

Нидерландын хөгжлийн агентлагтай хамтран 150 сая ам.долларын синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа. Синдикат зээлд ILX Funds, BlueOrchard, NTB, CDP, GCPF, Atlantic Forfaiting зэрэг байгууллага оролцсон байна.



**\$19,300,000**

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бичил жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор олон улсын хөрөнгө удирдлагын байгууллага болох Incofin болон Symbiotics-с 19 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татлаа.



# Хувьцааны мэдээлэл

## 2025 оны IV улирал

ХасБанк ХК (ХАС)-ын хувьцааны үнэ 2025 оны 12 сарын 31-нд 963.9 төгрөгөөр хаагдсан нь өмнөх оны хаалтын ханшаас 16.7 хувь, IPO хийсэн үнээс 42.4 хувиар өслөө. 2025 оны IV улирлын байдлаар нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг 164.1 төгрөг байна.

ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг Монголбанкны холбогдох зөвшөөрлийн дагуу 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ХасБанк 2025 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар нийт 2,672,816 ширхэг (нийт эргэлтэд гаргасан хувьцааны 0.25%) хувьцааг халаасалсан байна.


2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18 төгрөг буюу нийт 18.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилах Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар эцэслэн баталж, 2025 оны 10 сарын 16-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа.

### ХАС хувьцааны ханш, арилжааны хэмжээ



### Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг





# Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


2025 оны IV улирал

## 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

**20.1%** Байвал зохих доод хэмжээ 12.5%


## Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

**37.6%** Байвал зохих доод хэмжээ 25.0%



## Түргэн борлогдох актив

Нийт **2,257.5** тэрбум төгрөг





# Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-6.2%	-1.7%	-2.0%	-4.9%	-0.6%	-1.2%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-9.1%	-2.0%	-3.3%	-5.7%	-1.4%	-1.2%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	56.9%	41.7%	51.7%	46.3%	51.8%	54.8%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.2%	1.2%	1.2%	1.1%	1.1%	1.1%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.4%	7.9%	7.0%	6.8%	6.9%	8.0%

	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	1.7%	2.2%	1.7%	0.9%	1.0%	2.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	2.8%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%

Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	1.7%	2.3%	1.8%	0.9%	1.0%	2.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.4%	0.3%	0.3%	0.4%	0.4%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	2.8%	0.1%	0.0%	0.1%	0.1%	0.1%



# Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон түүний дэргэдэх хорооны хурал

2025 оны IV улирал

## Төлөөлөн удирдах зөвлөл

1

Хурал

1

Цахимсанал  
хураалт

10

Тогтоол

1

Сонирхлын  
зөрчилтэй  
хэлцэл



Засаглал, цалин  
урамшууллын  
хороо

1 удаагийн  
хурал



Эрсдэлийн  
удирдлагын  
хороо

1 удаагийн хурал  
4 удаагийн цахим  
санал хураалт



Нэр дэвшүүлэх  
хороо

1 удаагийн  
хурал



Аудитын  
хороо

1 удаагийн  
хурал



### Шинээр баталсан:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрэхээс сэргийлэх эрсдэлийн үнэлгээний аргачлал



### Шинээр баталсан:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- Харилцагчийг таньж мэдэх ерөнхий журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр





☎ (976)-75771888-(888)

✉ investor-relations@xacbank.mn

🌐 <https://www.xacbank.mn>